



АЙВЕНХОУ МАЙНЗ МОНГОЛИЯ ИНК КОМПАНИ

ОЮУ ТОЛГОЙ ТӨСӨЛ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМ

Улаанбаатар, 2008

БАТЛАВ:
БОЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.БАНЗРАГЧ



АММИ ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

А.МӨНХБАТ



БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР - 2008

ХЯНАСАН:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Г.ЦЭРЭНДОНДОВ

АММИ ХХК-НЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖЕР

Ж.ОЮУСУВД

БОЛОВСРУУЛСАН:

АММИ ХХК-НЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ АХЛАХ АЖИЛТАН

АММИ ХХК-НЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТАН

С.ДОРЖДЭРЭМ

Б.АЛТАНЦЭЦЭГ

2008 оны 02 сар

БАТЛАВ:

БОЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ГАЗРЫН ДАРГА

АММИ ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.БАНЗРАГЧ

А.МӨНХБАТ



БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР - 2008

ХЯНАСАН:

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

АММИ ХХК-НЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖЕР

Г.ЦЭРЭНДОНДОВ

Ж.ОЮУСУВД

БОЛОВСРУУЛСАН:

АММИ ХХК-НЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ АХЛАХ АЖИЛТАН

С.ДОРЖДЭРЭМ

АММИ ХХК-НЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТАН

Б.АЛТАНЦЭЦЭГ

2008 оны 02 сар

ГАРЧИГ

ОРШИЛ	4
1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЗОРИЛГО	5
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ НӨХЦӨЛ	6
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ	8
4. ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	12
5. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	16
6. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
7. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	26
8. БАЙГАЛИЙН НӨӨЦ БАЯЛАГ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР	32
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	37
ХАВСРАЛТ ЗУРАГ	

ОРШИЛ

АММИ ХХК Монгол улсын өмнөд говийн бүсэд орших Оюу Толгойн зэс-алтны ордын ашиглалтын 6709А лицензийг эзэмшдэг бөгөөд тус ордыг ил болон далд аргаар олборлох боломжтой юм.

Оюу Толгой төслийн үйл ажиллагаа нь ил болон далд уурхай, баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн байгууламжууд болон өндөр агуулгатай алт, зэсийн баяжмалыг хэрэглэгчид хүргэх гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Одоогоор Оюу Толгой төсөл нь энэхүү томоохон хэмжээний ордыг ашиглах олон үе шат бүхий цогцолбор төлөвлөгөөний зөвхөн эхний шатыг буюу уурхай байгуулах бэлтгэл ажлыг гүйцэтгэхийн хажуугаар гүний хайгуул судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийх боломжтой байна.

АММИ компани нь Монгол улсын Засгийн газартай Оюу толгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээг эцэслэн хийхээр ажиллаж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан үйл ажиллагааныхаа цар хүрээг 2008 онд бууруулан зөвхөн геологи хайгуулын ажил болон босоо ам 1-ийн 1300 м гүнд хайгуул судалгааны зориулалт бүхий хөндлөн малталт хийхээр төлөвлөөд байна.

АММИ ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд хуулиар хүлээсэн үүргийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар дэс дараатай хийлгэж байгаа бөгөөд тус үнэлгээний тайлан дахь зөвлөмжийн дагуу байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг жил бүр төлөвлөн, батлуулж ирсэн.

Ашигт малтмалын шинэчилэн найруулсан хуулийн дагуу Оюу Толгой төслийн Байгаль орчныг хамгаалах 2008 оны төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээ, хортой болон хор хөнөөл учруулж болзошгүй бодис, материалыг хадгалах, хяналт тавих менежментийн төлөвлөгөө, газрын гадаргуугийн болон гүний усыг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө ба бусад арга хэмжээг тусгаж өгөв. Тухайлбал геологи хайгуул, босоо нэвтрэлт, дайрганы уурхай уулын ажлын төлөвлөгөө ба Оюу Толгой төслийн 2008 онд хийж гүйцэтгэх бусад ажлын төлөвлөлт, тэдгээрээс байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй нөлөөллүүд, түүнээс сэргийлэх, багасгах арга хэмжээ, холбогдох зардлыг тодорхойлж өгсөн болно.

Энэхүү тайлан нь оршилоос гадна 8 бүлэг, 5 хүснэгт, 1 зураг, 4 хавсралт зураг бүхий нийт 42 хуудаснаас бүрдэнэ.

1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЗОРИЛГО

АММИ компанийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилго нь тус улсад явагдаж буй геологи хайгуулын үйл ажиллагааг олон улсын болон Монгол улсын байгаль орчны хуулиудын хүрээнд мөн компаниас баримталж буй байгаль орчны менежментийн үндсэн бодлогын дагуу явуулахад оршино.

АММИ ХХК нь байгаль орчныг хамгаалах талаарх бодлогыг дараах байдлаар тодорхойлсон:

- ✦ Байгаль орчны удирдлагын ISO 14000 олон улсын цуврал стандартуудад нийцсэн байгаль орчны менежментийн системийг нэвтрүүлэн, үйл ажиллагааг байнга хянаж сайжруулж байх нөхцөлөөр хангана;
- ✦ Бохирдлоос сэргийлэх, нөөц баялгийг үр ашигтай зарцуулах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг тодорхойлж, үнэлж, бууруулж, зохицуулах арга хэмжээ авна;
- ✦ Байгаль орчны талаархи хууль тогтоомж болон бусад бүх шаардлагад нийцүүлэх;
- ✦ Хайгуул, бүтээн байгуулалт, ашиглалт, уурхай хаах зэрэг өөрийн бүх үйл ажиллагааны явцад байгаль орчинд тавих анхаарлаа орхигдуулахгүй;
- ✦ Байгаль орчны талаар хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь туслах зорилгоор салбарын удирдлагуудад дэмжлэг үзүүлж, сургалт явуулна;
- ✦ Байгаль орчинд учруулсан нөлөөлөлд тогтмол үнэлэлт өгч, хяналт тавьж тайлагнана;
- ✦ Компанийн ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, нутгийн иргэдтэй байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, ажил хэрэгч харилцаа хөгжүүлнэ;
- ✦ Нутгийн ард иргэдийн уламжлагдаж ирсэн эрх, соёлын өвийг хүндэтгэж хамгаална.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ НӨХЦӨЛ

АММИ компанийн Оюу толгой төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутаг дэвсгэр дэх Оюу толгой гэдэг газарт нийтдээ 23,867 га газрыг хамарсан ашиглалтын 6709А лиценз бүхий талбайд явагдаж байна. Үүнд 2003 оны 12 сарын 23-д АММИ ХХК-д олгогдсон 6708А – Манахт, 6709А – Оюу Толгой, 6710А – Хөх Хад, 6711А – Улаан Уул зэрэг тусгай зөвшөөрлүүд бүхий талбайнууд орно.

Оюу толгой орд нь газар зүйн хувьд Галбын говийн нутаг дэвсгэрт хамаарна. Галбын говь манай орны хамгийн нам дор оршдог говь, цөлийн тэгш талархаг нутаг юм. Ерөнхий өндөршил нь далайн түвшнээс дээш нь 937.3м (Булан Сухай) - 1202.3м (Загалын Хүрэн Овоо) хооронд хэлбэлзэнэ.

Тус нутгийн геологийн тогтоц нилээд нийлмэл бөгөөд суурь хурдас нь цэрдийн настай конгломерат, элсэн чулуу, алевролит, неогенийн настай шавар бөгөөд тектоникийн хэрчигдэлд их орсон нилээд нийлмэл тогтоцтой юм. Харин замын суурь болдог дөрөвдөгч, орчин үеийн хурдасны хувьд нилээд зузаан бөгөөд 20-180 м хүртэл зузаантай элс, хайрга, шавар үелэн тогтсон байдаг.

Оюу толгой орчмын нутагт эх газрын эрс тэс уур амьсгал давамгайлдаг. Хавар намартаа сэрүүн, зундаа халуун, өвөл нь хүйтэн. Хавар нь хуурай салхитай, үе үе хүчтэй шуурдаг. Говийн эрс тэс уур амьсгал төслийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн нөхцөлд хүчтэй нөлөөлөх хүчин зүйл болж байна. Температурын хэлбэлзэл маш их буюу өвөлдөө доод тал нь -31°C , зундаа 40°C –аас давж гарах нь элбэг.

Оюу Толгой орчмын нутаг дэвсгэр хүн ам цөөтэй, үйлдвэрлэл дэд бүтэц сул хөгжсөн, хүрээлэн буй орчны агаарт нөлөөлөх хог хаягдлын томоохон эх үүсвэр, бохирдуулагч эх үүсвэр байхгүй нутаг дэвсгэрт оршдог. Улирлын шинж чанартай шороон шуургыг л тооцохгүй бол энэ нутаг нь үндсэндээ цэвэр цэнгэг агаартай юм.

Түр зуурын урсгалтай голууд нь хур борооны үеэр түр урсаад хэд хоногийн дараа хатаж, ширгэдэг. Зуны хүчтэй салхи шуургатай борооны дараа хуурай сайр, гольдролуудын дагуу богино хугацаанд маш хүчтэй хуйларсан урсгал үүсгэх (уруй) ба үүнийг говийн “догшин” үер гэж нэрлэдэг. Төсөл хэрэгжүүлж буй Оюу Толгойн лицензийн талбайн баруун болон баруун урд талаар тухайн нутгийн экологид чухал ач холбогдол бүхий Ундайн голын хуурай сайр дайран өнгөрдөг бөгөөд уг голын гольдролын хөрсний дээд хэсэгт гүний суурь чулуулаг хөрсөнд ойртсон хэсгээс ундрэн гарах задгай булаг шанд хэд хэд бий. Эдгээрээс хамгийн том нь хайгуулын анги одоогоор байрлаж буй газрын баруун өмнө талд байх Бор Овооны булаг юм. Ийм горхинууд өвөл хөлдөж мөс нь голын эргээс хагас метр хүртэл илүү гарах үе бий. Эдгээр цэвэр ус бүхий горхи булгууд нь зэрлэг ан амьтан, мал, мөн зуны саруудад элбэг тааралдах Монгол бахын амьдралыг тэтгэж байдаг.

Өрөмдлөгийн ажлын үр дүнд илрүүлсэн ул хөрсний ус хүртэлх гүний хэмжээ төслийн нутаг дэвсгэрт янз бүр байна. Энэ хэмжээ Ундайн голын гольдролын дагуу гадаргаас 3 м хүрэхгүй байхад Өмнөд болон Төв ордуудад 65 м хүрч байна.

Хөрсний хээрийн судалгаагаар говийн хөрсний төрөлд хамаарах 3 дэд төрлийн хөрсийг тэмдэглэсэн. Үүнд:

1. Цөлийн цайвар бор
2. Цөлөрхөг хээрийн цайвар бор
3. Цөлөрхөг хээрийн саарал бор хөрс орно.

Эдгээр хөрсний гол онцлог, шинж чанар, химийн найрлага болон бусад үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүйгээр нь Оюу Толгой ордоос зэс-алт боловсруулах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнээс олж үзэх боломжтой.

Оюу Толгой орчмын ургамал нь Төв Азийн цөл болон цөлөрхөг хээрийн ургамлын аймгийн төрөлд багтана. Цөлийн өргөн уудам тэгш тал ба нам толгод нь ган гачигт тэсвэртэй жижиг бут, сөөгөөр (<0.5 м) армаг тармаг бүрхэгдсэн. Түр зуурын урсгалтай голын гольдролууд, хуурай жалгууд болон шал хөрс нь зарим зүйлийн мод ургах нөхцлийг бүрдүүлэх бөгөөд, бутнууд нь гүний ус ойрхон байдаг газруудад голчлон ургана.

Оюу Толгойн нутаг дэвсгэрийн амьтны аймгийг 2002, 2003 онуудад судласан бөгөөд гол үр дүнг дараах хүснэгтээр үзүүлэв:

Хүснэгт 1. Амьтны аймгийн судалгаа


№	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Оюу Толгой дахь хэмжээ	Хэмжээний		Тайлбар
				Хамгийн их	Хамгийн бага	
1	Нийт зүйлийн тоо	тоо	298	518	35	
2	Тоо толгойн нягтрал	тоо /км ²	1.7	2.3	0.01	
3	Амьтдын биомасс	тонн/км ²	0.07	0.3	0.0	
4	Маш ховор болон ховор амьтад	тоо	12	48		
5	Эндемик болон дархан цаазат амьтад	тоо	10			
6	Ангийн зүйлүүд	тоо	18			
7	Хөхтөн	тоо	43	56	21	
8	Шувууд	тоо	62	100		
9	Хоёр нутагтан	тоо	1	0	0	
10	Мөлхөгчид	тоо	10	22	0	Монголд 22
11	Загас	тоо	0	0	0	
12	Шавьж	зүйлийн тоо	183	340	0	6-овог, 40 зүйл

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Байгаль орчны менежментийн системийн хүрээнд байгаль орчныг хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй холбоотой компанийн дотоод журмыг (нийт 25) одоогоор боловсруулан Оюу Толгой төслийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна. Үүнээс Оюу Толгой төслийн 2008 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд зайлшгүй мөрдөж ажиллах журмын заримаас дурьдвал:

1. Хог хягдлын менежмент
2. Хаягдал тос, бохирдуулагч бодисын менежмент
3. Асгаралтын үед авах арга хэмжээ
4. Аюултай, хортой бодисын ашиглалт, хадгалалт, тэвэрлэлт
5. Тоосны шинжилгээний хөтөлбөр
6. Тоосжилтын хяналт, бууруулах арга хэмжээ
7. Бохир ус цэвэршүүлэх байгууламжийн үйл ажиллагаа
8. Хаягдал бохир усны стандарт
9. Газрын элэгдэл эвдрэл
10. Археологи, палеонтологийн шинэ олдвор
11. Гэрээлэгч компанийн БО, Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага
12. Хайгуулын үед байгаль орчныг хамгаалах арга хэмжээ
13. Гэрээлэгч компанийн Байгаль орчныг хамгаалах талаар хүлээх үүрэг

EMS-ийн хүрээнд байгаль орчны чанарын удирдлагын тогтолцооны ISO 14000 стандартыг Оюу Толгой төсөлд хэрэгжүүлэх үе шатыг схемчлэн 1-р зургаар үзүүлэв.



Зураг 1. Байгаль орчны чанарын удирдлагын тогтолцооны ISO 14000 стандартыг хэрэгжүүлэх үе шатын схем

Хууль эрх зүйн орчин

Байгаль орчны талаар тусгасан доорх хууль тогтоомжийн заалтуудад Оюу Толгой төслийн үйл ажиллагаа нийцсэн байх ёстой. Үүнд:

Хуулиуд:

- ⇒ БОНБУ-ний тухай хууль 2001
- ⇒ Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995
- ⇒ Ашигт малтмалын тухай хууль, шинэчилсэн найруулга 2006
- ⇒ Газрын тухай хууль 2002
- ⇒ Газрын хэвлийн тухай хууль 1988
- ⇒ Газрын төлбөрийн тухай хууль 1997
- ⇒ Агаарын тухай хууль 1995
- ⇒ Усны тухай хууль 2004
- ⇒ Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хууль 1995
- ⇒ Байгалийн ургамлын тухай 1995
- ⇒ Амьтны аймгийн тухай 1995
- ⇒ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай 2000
- ⇒ Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль 1995
- ⇒ Хог хаягдлын тухай хууль 2004

Журмууд:

- ⇒ Ус бохирдуулсны төлбөрийн журам. Улсын байгаль орчны зөвлөлийн тушаал №6, 1992
- ⇒ Хаягдал бохир усны цооногийг доторлож ашиглах журам. БО-ны болон ЭМ-ийн сайд нарын хамтарсан тушаал, 169/171 1995
- ⇒ Усны нөөцийг хамгаалах журам. БО-ны болон ЭМ-ийн сайд нарын хамтарсан тушаал, 143/А/352, 1997
- ⇒ Усан хангамжийн нөөцийн бүсийн хамгаалалтын болон эрүүл ахуйн дүрэм. ҮХ, БО, ЭМ-ийн сайд нарын хамтарсан тушаал, 167/335/А/171
- ⇒ Бохир ус хаях цэг сонгох журам. БО, ҮХ, ЭМ-ийн сайд нарын хамтарсан тушаал
- ⇒ Хаягдал ус зайлуулах цэг сонгох журам. БО-ны сайдын тушаал 167/335/а/171, 1995
- ⇒ Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, түр байрлуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, хадгалах, устгах журам. Засгийн газрын тогтоол №135. 2002 оны 7 сарын
- ⇒ Геологийн судалгаа болон олборлох ажиллагаагаар үүссэн газрын өөрчлөлт эвдрэлийг сэргээн засварлахад зориулан мөнгө хуримтлуулах журам БО-ны ба ХААҮХ-ны сайдын хамтарсан тушаал №89/4/124 (1998)

Стандартууд:

- ⇒ MNS 4915:2000-Байгаль орчин, Ашигт малтмал эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага

- ⇒ MNS 4916:2000-Байгаль орчин, Алтны шороон ордыг ил уурхайгаар ашиглах явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага
- ⇒ MNS 4917:2000-Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт. Техникийн шаардлага
- ⇒ MNS 4918:2000-Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
- ⇒ MNS 4919:2000-Байгаль орчин. Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага
- ⇒ MNS 4920:2000-Байгаль орчин. Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
- ⇒ MNS 0017-5-1-18:1983-Сэргээн сайжруулах. Эвдэрсэн газрын ангилал
- ⇒ MNS 0017-5-1-19:1992-Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлага
- ⇒ MNS 4585:1998-Агаар орчны чанарын үзүүлэлт, ерөнхий шаардлага
- ⇒ MNS 0017-2-3-16:1988-Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам
- ⇒ MNS 4586:1998-Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
- ⇒ MNS 4867:1999-Усны чанар. Дээж авах 3-р хэсэг. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж
- ⇒ MNS 3342:1982-Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Газар доорх усыг бохирдлоос хамгаалах. Ерөнхий шаардлага
- ⇒ MNS 3597:1983-Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Гадаргуугийн ба газрын доорх усыг эрдэс бордооны бохирдлоос хамгаалах. ерөнхий шаардлага
- ⇒ MNS ISO 5667-11:2000-Усны чанар. Дээж авах. 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж
- ⇒ MNS 0899:1992-Унд ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам ба эрүүл ахуйн шаардлага
- ⇒ MNS 0900:1992-Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
- ⇒ MNS 3297:1991-Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм
- ⇒ MNS 3298:1991-Байгаль хамгаалал. Хөрс шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд

4. ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Геологи хайгуулын ажил

Оюу Толгой төслийн 2008 оны хайгуулийн ажлын урьдчилсан төлөвлөгөөгөөр топо зураглал, геофизикийн хайгуул болон өрөмдлөг судалгааны ажлуудыг хийх болно. Үүнээс 5 ширхэг өрмийн суурь машинаар Javhlant 3150X талбайд 33200м буюу 20-22 цооног шинээр өрөмдөж геологийн нарийвчилсан хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөж байна. Өрөмдлөгийн ажилд RD1500, UDR650, Канадын JKS300, CS1000, Longyear 44 зэрэг алмазан өрөмдлөгийн машин ашиглах бөгөөд эдгээр нь давхар яндантай, өрөмдлөгийн яндангийнхаа цувааг сугалахгүйгээр кернээ авдаг технологитой, өрөмдлөгийн кернийн диаметр PQ (103.2mm), HQ (77.8), NQ (60.3mm), BQ (46mm) байдаг.

2008 онд хийх өрөмдлөгийн ажлыг Межер Дриллинг компани дангаар хийж гүйцэтгэх бөгөөд тус компани нь Оюу Толгой дахь засварын цехэд буюу зориулалтын талбайд өрмийн суурь машинуудын засвар үйлчилгээг хийдэг. Үйлчилгээ хийхэд ялгарах хаягдал тосыг түр хадгалах 25 тн багтаамжтай савыг уг талбайдаа байршуулсан байна.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

Газрын хэвлий, хөрс ургамлан бүхэвч, гадаргын болон газрын доорхи ус, агаарын чанар эзрэгт сөргөөр нөлөөлж болзошгүй. Геологи хайгуулын ажлын үед байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн бөгөөд гол сөрөг нөлөөллөөс дурьдвал:

- өрмийн зумпны нүх ухах,
- өрмийн зумпний шингэнд ус ашиглах, зууралдуулагч бодисын уусмал бэлтгэх
- зумпны шингэн нүхнээс хальж асгарах
- зумпны нүхэнд мал, амьтан унаж осолдох
- цооногийн талбайд хөрс хуулах, ургамлын бүрхэвчийг устгах
- цооногийн талбайд хог хаягдал хийсэх, шатах тослох материал асгарч хөрсийг бохирдуулах
- газрын доорхи уст үеүд холилдох
- өрмийн цооногууд хооронд шинээр зам гарах гэх мэт.

Бууруулах арга хэмжээ

- ✓ Зумпны нүхийг шинээр ухах үедээ гарсан шороогоор далан хийж манах, нэмэлт хашлага саад хийж, хараа хяналтгүй мал амьтан ойртож, унаж осолдохоос сэргийлэх
- ✓ Зумпны шингэнд холих бодист олон улсын стандарт ангиллаар аюулгүй гэж үнэлсэн, бичил организмын нөлөөгөөр өөрөө задрах чадвартай бодисыг ашиглах
- ✓ Зумпны шингэнд ашиглах усыг аль болох дахин ашиглах, цэвэршүүлсэн усыг ашиглах зэргээр усны нөөцийг хомсдохоос сэргийлэх
- ✓ Малчдын гар худгийн уснаас ямар ч тохиолдолд ус авч ашиглахгүй байх

- ✓ Өрмийн суурь машин нүүх үед зумпны нүхийг нэн даруй булж тэгшлэх, холбогдох стандартын дагуу нөхөн сэргээлтийг хийж үлдээх
- ✓ Цооногийн талбайд өрмийн суурь машинд засвар үйлчилгээг хийхээс аль болох зайлсхийх, гарцаагүй хийх болсон тохиолдолд асгаралтаас сэргийлэх тосгуур, шингээгч материалуудыг бэлэн байлгах
- ✓ Өрмийн суурь машинуудын моторын дор зориулалтын тосгуур байрлуулан техникийн тос, хаягдал шингэн хөрсөнд асгарахаас сэргийлэх
- ✓ Хаягдал тосыг түр хадгалах саванд юүлэх үед гадуур нь асгарахаас сэргийлэх, шатах тослох материалын асгаралт болсон тохиолдолд тухайн ээлжийн ахлах ажилтнаар дамжуулан БО хэлтэст яаралтай мэдэгдэж байх, асгаралтын үед мөрдөж ажиллах журмыг дагаж мөрдөх
- ✓ Өрмийн цооногийн талбайд үүсэн гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж, зохих журмын дагуу байгаль орчинд халгүйгээр устгалд оруулах, шаардлага хангасан хогийн савуудыг байршуулж, хогийг тээвэрлэн хаях үйл ажиллагааг тогтмолжуулах
- ✓ Цооног хооронд явах гол ашиглагддаг замуудыг сайжруулан, усалгааг тогтмолжуулах, шинээр зам үүсгэхгүй байхад анхаарах

4.2. Далд уурхайн бэлтгэл ажил

Оюу Толгой ордын Хойд Хюго хэсгийн газрын гүнд хийх нарийвчилсан хайгуулын ажил, ирээдүйн далд уурхайн ам байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Босоо ам 1, ба Босоо ам 2-ыг байгуулах ажлыг урьд жилүүдэд эхлүүлсэн. Гэвч хөрөнгө оруулалтын гэрээний байдлаас шалтгаалан Оюу Толгой төслийн үйл ажиллагааны цар хүрээг багасгасан горимоор ажиллуулж байгаа бөгөөд одоогоор зөвхөн Босоо ам 1-ийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.

Ашигт малтмалын хуулийн дагуу Хойд Хюго ордын нарийвчилсан хайгуул хийх босоо нэвтрэлийн уулын ажлын 2008 оны төлөвлөгөөг боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллагаар батлуулж ажиллана.

Босоо ам 1-ийн нэвтрэлийн төлөвлөсөн гүн болох 1385 м хэмжээнд 2008 оны 1 дүгээр сард хүрсэн тул 2008 онд 1300 м-ийн түвшингээс хоёр тийш хойд болон зүүн зүгт чиглэсэн хөндлөн малталтуудыг гүйцэтгэх болно. Хөндлөн малталтын өргөн нь 5 м, өндөр нь 5 м байх бөгөөд хойд зүгт 630 м, зүүн зүгт 1030 м-ийн хөндлөн малталтын ажлыг гүйцэтгэх ба өрөмдлөгөөг далд уурхайн зориулалтын техник хэрэгсэл (JUMBO; TORO) ашиглан явуулах юм.

Далд уурхайн бэлтгэл ажлын хүрээнд ухагдан гарах уулын цул чулуулгийг босоо амнаас урагш 200 м зайд байрлах зориулалтын талбайд үргэлжлүүлэн тээвэрлэж, овоолно. Босоо ам 1-ийн газрын гүн дэх нэвтрэлтийн ажлын дүнд одоогоор газрын гүний ус илрээгүй тул шүүрэлт явагдаж шавхалт зэрэг ажил хийгдээгүй байна. Хаягдал чулуулгийн овоолго болон далд уурхайн бэлтгэл ажлын явцад шүүрсэн усыг соруулах, тунаах далангуудыг стандартын дагуу бэлтгэсэн байгаа.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

Газрын хэвлий, газрын доорхи ус эзрэгт сөргөөр нөлөөлж болзошгүй бөгөөд гол сөрөг нөлөөллөөс дурьдвал:

- Хаягдал чулуулгийн овоолгоос шүүрсэн ус, хур тунадасны дараагаар угаагдан гарах шингэн нь хүчиллэг шинж чанартай байх, ойролцоох газрын хөрс, газрын доорхи усны нөөцийг бохирдуулах
- Хаягдал чулуулгийн овоолго их хэмжээний хуурайшилтын улмаас агаарт тоос дэгдээх эх үүсвэр болох
- Хаягдал чулуулгийн овоолго их хэмжээний хур бороотой үед үер, уруйд автаж орчинд тархаж бохирдуулах
- Далд уурхайн нэвтрэлтийн ажлын үед шүүрсэн усыг хэмнэлтгүй ашиглах
- Босоо ам 1-ийн хашаалсан талбай дахь дулааны бойлер, химийн бодисууд, цахилгааны эх үүсвэрүүд, тэдгээрийн түлшний агуулах сав, ахуйн хэрэглээний ус гэх мэт байгаль орчинд нөлөөлөх олон талын хүчин зүйл байж болно.

Бууруулах арга хэмжээ

- ✓ Хаягдал чулуулгийн овоолгийн суурийг үл нэвчүүлэх шинж чанартай хийх, чулуулгийн дизайныг олон улсын холбогдох стандартад заасан шаардлагын дагуу гүйцэтгэх
- ✓ Хаягдал чулуулгийн овоолгоос тунаах буюу шүүрүүлэх далангуудыг зохих ёсоор бэлтгэж, ус чийг хуримтлагдсан тохиолдолд хүчиллэг үүсгэлтийн шинжилгээ хийж байх
- ✓ Хаягдал чулуулгийн овоолгыг тогтмол хэмжиж, зураглалыг үйлдэж баримтжуулж байх
- ✓ Далд уурхайн бэлтгэл ажлын газрын гүн дэх нэвтрэлтийн үед ус илэрсэн тохиолдолд усыг насосоор соруулан зориулалтын даланд хуримтлуулах
- ✓ Газрын гүний шавхалтын усанд шинжилгээ хийж, үр дүнг харгалзан үзсэний үндсэн дээр дахин ашиглах төлөвлөгөө боловсруулах
- ✓ Босоо ам 1-ийн хашаалсан талбайд үүсэн гарах хог хаягдал, ахуйн бохир ус, химийн бодисын хадгалалт болон дулааны бойлер, дизел генераторууд зэргээс үүсч болох аливаа эрсдэлүүдийг бууруулахын тулд Оюу Толгой төслийн хэмжээнд мөрдөж буй холбогдох журам, байгаль орчны төлөвлөгөөнд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ

4.3. Дайрганы уурхай, бутлуур, бетон зуурмагийн цех

Оюу Толгойн 6709А лицензийн талбайн хойд хэсэгт байрлах Дугатын хярын орд буюу дайрганы 2-р орд нь 50 орчим га талбайг хамарсан 4435984 шоо метр нөөцтэй бөгөөд олборлох үйл ажиллагааг 2006 оны 6-р сараас эхлүүлсэн. 2008 онд Оюу Толгой төслийн үйл ажиллагааны цар хүрээг багасгасантай холбогдуулан Дугатын хярын дайрганы уурхайд энэ онд олборлолт явуулалгүй, 2007 онд бэлтгэсэн нөөцөд түшиглэн дотоодын хэрэгцээний бетон зуурмагийг бэлтгэх төлөвлөгөөтэй байна. Иймд Дугатын хярын ордод өрөмдлөг, тэсэлгээ, тээвэрлэлт, нөхөн сэргээлт зэрэг ямар нэг үйл ажиллагаа явуулахгүй, мөн тус цогцолборын бутлуурын суурь машинд дайрга буталж дайрга бэлтгэх үйл ажиллагаа хийгдэхгүй.

Гэвч Дугатын хярын уурхайн уулын ажлын төлөвлөгөөг 2008 онд шинэчлэн батлуулж, хэрэгцээ гарсан тохиолдолд ашиглахаар төлөвлөж байгаа бөгөөд уг дайрганы уурхайг ашигласан тохиолдолд Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг нэмэлтээр батлуулах болно.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

Бетон зуурмагийн цехийн үйл ажиллагаа үргэлжлэн явагдах бөгөөд үүнтэй холбогдон дараах болзошгүй сөрөг нөлөөлөл хөрс, газрын доорхи болон гадаргын ус зэрэгт нөлөөлж болзошгүй. Үүнд:

- Бутлуурын цехэд ашиглах химийн бодисууд асгарч, хөрсийг бохирдуулах
- Бэлэн зуурмаг тээвэрлэх машинуудыг угаах үед үүсэх шүлтлэг шингэнийг хяналтгүйгээр асгаснаас хөрс, газрын доорхи усны чанарт сөргөөр нөлөөлөх
- Цемент, цементний уут зэрэг нь орчинд хаягдаж бохирдуулах
- Бетон зуурмагийн үлдэгдэл, хог хаягдлыг зориулалтын газарт устгалд оруулахгүй байх зэрэг орж байна.

Бууруулах арга хэмжээ

- ✓ Бетон зуурмагийн цехээс үүсэн гарах бүх төрлийн хог хаягдлыг ангилан ялгаж, байгаль орчинд халгүй аргаар устгалд оруулах, дахин ашиглах төлөвлөгөөтэй ажиллах
- ✓ Химийн бодисын ашиглалт, хадгалалтын горимыг чанд сахиж ажиллах, химийн бодисуудын агуулах сав, түр хадгалах талбайг шаардлагад нийцүүлэн тохижуулах, шошго тэмдэг, анхааруулах тэмдгийг байршуулах, дотоодын хяналт шалгалт, бүртгэл тооллогыг тогтмолжуулах.

4.4. Усны эх үүсвэрүүд

- Ус цэвэршүүлэх байгууламж
- Ажилчдын суурин
- Хогийн цэг
- Шатахуун түгээх станц
- Генераторууд, цахилгааны эх үүсвэр
- Механик засварын цех
- Нислэгийн зурвас
- Тэсрэх бодисын агуулах
- Материалын агуулах

5. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

АММИ компани нь 2002 оны 7-р сараас Оюу Толгой Төслийн Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Үнэлгээний (БОНБҮ) ажлыг төслийн талбайд эхлүүлсэн юм. Энэхүү ажлын хүрээнд төслийн байгаль орчны суурь нөхцөл, төлөв байдал, онцлог болон нийгэм-эдийн засгийн судалгаануудыг хамруулсан бөгөөд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчны үнэлгээ хийх эрх бүхий “Эко Трейд” ХХК гүйцэтгэсэн. Судалгааны ажилд Айвенхоу Майнз компанийн талаас олон улсын байгаль орчны асуудлаар зөвлөгөө өгөх эрх бүхий Австрали Улсын “Sustainability Pty Ltd” компани зөвлөхөөр оролцож, үнэлгээний тайлангуудыг олон улсын эрх зүйн акт бичгүүдэд нийцүүлэн зохицуулах үүрэг гүйцэтгэж байна.

Одоогийн байдлаар Оюу Толгой төслийн хүрээнд дараах үнэлгээний тайлангуудыг БОЯ-аар батлуулсан байгаа бөгөөд тухайн үйл ажиллагаа эхлэх үед мөрдөн ажиллаж байна.

Үүнд:

1. Оюу Толгой - Гашуун Сухайтын зам ба дэд бүтцийн зурвасын БОНБНҮ-ний тайлан. 2004.04.
2. Оюу толгойн Хюго хэсэгт нэвтрэх 1-р босоо нэвтрэлтийн БОНБ-н нэмэлт, тодотгол үнэлгээний тайлан. 2005.06
3. Галбын говь - Гүний хоолой дахь газрын доорхи усны нөөцийг Оюу толгойд ашиглах төслийн БОНБНҮ-ний тайлан. 2005.10
4. Оюу толгойн Хюго хэсэгт нэвтрэх 2-р босоо нэвтрэлтийн БОНБ-н нэмэлт, тодотгол үнэлгээний тайлан. 2006.11.
5. Оюу толгой-Гашуун сухайтын замын зурвасын БОНБНҮ-ний тайланд оруулах нэмэлт тодотгол үнэлгээний тайлан. 2006.10
6. Оюу Толгой дахь барилгын ажилчдын түр суурингийн бохир ус цэвэрлэх байгууламжийн БОНБНҮ. 2007.05
7. Бетон зуурмагийн чулуулаг олборлох, бетон цехийн үйлдвэрлэлийн БОНБНҮ. 2007.03
8. Оюу Толгойн онгоцны буудлыг нүүлгэн шилжүүлэх төслийн БОНБНҮ. 2007.06
9. Оюу Толгойд баригдах Дизель станцын БОНБНҮ. 2007.08

Мөн дор дурьдсан нэмэлт үнэлгээний ажлууд боловсруулах шатандаа явагдаж байна. Үүнд:

1. Гүний хоолойгоос ус татах шугамын дагуух дэд бүтцийн зурвасын БОНБНҮ
2. Цахилгаан станцын БОНБНҮ
3. Галбын говь - Гүний хоолой дахь газрын доорхи усны нөөцийн нэмэлт судалгаагаар тогтоогдсон газрын доорхи усны нөөцийг Оюу толгойд ашиглах төслийн БОНБНҮ-ний нэмэлт, тодотгол тайлан

6. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь Оюу Толгой төслийн хүрээнд батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд, тэдгээртэй нийцүүлэн боловсруулсан АММИ ХХК-ын дотоод журмуудад заасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн хураангуй, нэгтгэл болно (хүснэгт 3).

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа 2008 онд төлөвлөсөн Оюу Толгой төслийн үйл ажиллагаанууд, тэдгээрийн зүгээс байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй хүчин зүйлүүдийг тодотгож, урьд өмнө нь батлагдсан нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тохирох заалт, заавар зөвлөмж буюу нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг дэлгэрүүлж бичив. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг тус бүрд нь нарийвчлан төлөвлөсөн бөгөөд үүнд зөвхөн шууд зардлуудыг тогтоож, шууд бус хамааралтай буюу тухайн заалттай холбогдон гарах бусад туслах чанарын ажлуудын зардал ороогүй.

Оюу Толгой төслийн 2008 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах үед хийхээр төлөвлөөгүй аливаа ажил, үйл ажиллагааг тухайн онд төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр болсон тохиолдол бүрт байгаль орчныг хамгаалах нэмэлт төлөвлөгөөг боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллагаар батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах болно.

7. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Оюу Толгой төслийг хэрэгжүүлэх явцад АММИ ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тухайн орчинд зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, холбогдон гарах зарим зардлуудын хамт тодорхойлж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулан 4-р хүснэгтэд үзүүлэв.

Оюу Толгой төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах ОХШХ нь тус төсөл хэрэгжих орчны байгалийн болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичгийн нэг юм.

Оюу Толгойн уурхай болон баяжуулах үйлдвэр, түүний үйлчилгээний байгууламжуудыг барьж байгуулах болон төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад хяналт шинжилгээний ажлыг энд тусгасан хугацаа болон аргачлалын дагуу үргэлжлүүлэн хийх нь тухайн төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг шуурхай тогтоохоос гадна түүний олон жилийн судалгааны мэдээ материал нь говь нутгийн хөрс, ургамал, гадаргын ба газрын доорх ус зэрэг экосистемийн бүрдэл хэсгүүдийн хоорондын харилцан шүтэлцээг тодорхойлж, тэдгээрийн талаарх шинжлэх ухааны мэдлэгийг бий болгох чухал хэрэглэгдэхүүн болно.

Жил бүр хийгдсэн хяналт, шинжилгээний үзүүлэлтүүдийг анхааралтай судалж үзэж байх нь цаашдаа байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт оршин суугчдыг төслийн нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүү үндэслэлтэй болгох юм. Нөгөө талаас ОХШХ-г улам боловсронгуй болгох хяналт, шинжилгээ хийж байгаа объектоо бүрэн хамарч эсэхийг хянахад чухал ач холбогдолтой байх болно.

Оюу Толгой төслийн байгаль орчныг хамгаалах 2008 оны төлөвлөгөөний хүрээнд боловсруулсан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр заавал хийх ёстой гэж заасан боловч хяналт явуулж эхлэх хугацаа нь болоогүй буюу тухайн төслийг хэрэгжүүлж эхлэх үед хийх ёстой гэж заасан зарим үзүүлэлтүүдийг нэмж оруулж өглөө. Учир нь тэдгээр хэмжилт, хяналт шинжилгээг тухайн холбогдох төслийн үйл ажиллагаа явагдаж эхлэхээс өмнө хийж эхлэсэнээр орчны суурь нөхцлийн талаар олон жилийн мэдээлэлтэй болох, сүүлд нь төслийн зүгээс үзүүлж буй нөлөөллийг бодит байдал дээр үнэлж, дүгнэхэд үнэтэй баримт, судлагдахуун болох болно гэж үзсэн юм.

8. БАЙГАЛИЙН НӨӨЦ БАЯЛАГ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

БОХ төлөвлөгөө болон Монгол улсын холбогдох хууль, журмын дагуу энэ онд аж ахуйн нэгжийн газар ашиглалтын төлбөрийг гэрээний дагуу, хайрга, дайрга, элс, орон нутгийн зам ашигласны төлбөрийг орон нутгийн захиргаатай гүйцэтгэлээр улирал тутамд тооцох болно.

Оюу Толгой дахь унд ахуй болон үйлдвэрлэлийн зориулалтаар авч ашиглах усны төлбөрийг сар тутамд тоолуурын заалтыг үндэслэн төлөх болно.

2008 онд байгаль орчныг хамгаалах арга хэмжэний зардал болон орон нутгийн төсөвт байгалийн нөөц баялаг ашигласны төлбөрийн хэлбэрээр оруулах хөрөнгийг урьдчилсан байдлаар төлөвлөж доор үзүүлэв.

Хүснэгт 5. 2008 онд байгаль орчныг хамгаалах арга хэмжээ болон зардал

№	Байгаль орчныг хамгаалах ажлууд	Тоо хэмжээ	Зардал /төг-өөр/
1.	Нөхөн сэргээлтийн ажил		
	Өрмийн зумп булаах	1020 м ³ /жил	780 000
	Суваг, шуудуу дарах, техникийн нөхөн сэргээлт	10 000 м ³ /жил	3 895 000
2.	Хог хаягдлыг зайлуулах, цэвэрлэх		1 125 000
3.	Хайгуулын ангийн орчимд, зам дагуу, уурхайн хэсэгт усалгаа хийх	36 390 м ³ /жил	1 500 000
4.	Усны нөөцийг хамгаалах		400 000
5.	Биологийн нөхөн сэргээлт хийх туршилт		2 300 000
6.	Хяналт шалгалтууд		
6.1	Байгаль орчны дотоодын хяналт, шалгалтууд	7 хоног, сар тутам	
6.2	Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн хяналт		Улиралд 1 удаа
7.	Хойд Хюго хэсэгт нэвтрэх босоо малгалтын хөндлөн нэвтрэлт Шүүрэлтийн усыг тунгаах далан		Тус бүр хамгаалах арга хэмжээг зааж өгсөн. Тухайн төслийн зардалд тооцоолсон
8.	Чулууны ил уурхай, бутлах, бетон цех - Тоосжилтыг дарах усалгаа хийх		
9.	Элс авах талбай (гүний усыг ил гаргахгүй)		
10.	Мониторинг		
10.1	Усны		Графикийн дагуу
10.2	Хөрс ургамлын		хийгдэнэ
10.3	Агаарын чанарын		
Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд			10 000 000

11.	Байгаль орчны төлбөр хураамж		
11.1	Ус ашигласны:	<i>Гэрээнд:</i>	
	- ахуйн (30 төг/м ³)	56 736 м ³ /жил	1 702 080
	- үйлдвэрлэлийн (50 төг/м ³)	122688 м ³ /жил	6 134 400
11.2	- хайрга ашигласны (50 төг/м ³)	гүйцэтгэлээр	
	- элс ашигласны (100 төг/м ³)		
	- дайрга ашигласны (100 төг/ м ³)		
11.3	Үйлчилгээний зориулалтаар газар ашигласны	53.04 га	2 652 000
	Үйлдвэрлэл уурхайн зориулалтаар газар ашигласны	2455.6 га	245 560 000
11.4	Орон нутгийн зам ашигласны	170 км x 7500 ₮	1 275 000
Орон нутагт төлөх байгаль орчны төлбөр хураамжууд			257 323 480

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн тайлант хугацаа

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан байгаль хамгаалах арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн байдалд АММИ ХХК-ын байгаль орчны ажилтнууд тогтмол хяналт тавьж ажиллах бөгөөд 7 хоног тутамд болон сар бүр дотоод журмын дагуу тайлан бэлдэж хэрэгжилтийн байдлыг үнэлүүлэх юм.

Түүнчлэн байгаль орчинд сөргөөр нөлөөлсөн аливаа зөрчил, буруутай үйлдэл, стандартын шаардлагаас доогуур нөхцөл байдал бүгдийг нь бүртгэх жагсаалт хөтлөж байх бөгөөд энэ нь тухайн зөрчлийг арилгах арга хэмжээ, хугацаа, хариуцах эзэн зэргийг тодорхойлж өгсөн чухал баримт бичиг болно. Хэрэв тухайн хэрэг зөрчил нь хамрах цар хүрээ, нөлөөлөх байдлын зэргээрээ байгаль орчин, хүний эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахуйц байгаа тохиолдолд аймаг, сум, орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллага, эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж сөрөг нөлөөллийг бууруулах тал дээр хамтран ажиллах болно.

Ашигт малтмалын тухай хуулийн дагуу Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, орчны нөхөн сэргээлтийн ажлын биелэлтийн байдалд сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, аймгийн байгаль орчны албаар хянуулсаны үндсэн дээр холбогдох тайланг Монгол улсын Байгаль Орчны Яаманд хүргүүлэх юм.

ОТ хайгуулын ангид байгаа шаардлагатай бичиг баримтуудын жагсаалт

1. АММИ компанийн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн сертификат
2. Хайгуулын босоо малталт нэвтрэх Рэдпаф Монголия компанийн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн сертификат
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийж буй Эко-трейд ХХК-ийн гэрчилгээ
4. АММИ компанийн ашиглалтын лицензүүд 6710а, 6711а, 6709а, 6708а
5. Хайгуулын ажлын үед баримтлах байгаль орчныг хамгаалах ерөнхий төлөвлөгөө
6. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө-2004-2006
7. Хайгуулын босоо малталтын БОХ нэмэлт төлөвлөгөө-2004
8. Хайгуулын босоо малталт хийх зөвшөөрлийн бичиг. АМХЭГ-ын 4-7339 тоот бичиг
9. Хайгуулын босоо малталт дээр тэсэлгээ хийх зөвшөөрлийн бичиг 97/04
10. Ханбогд сум АММИ компанийн хооронд хийсэн газар ашиглалтын гэрээ
11. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулах тухай Ханбогд сумын засаг даргын захирамж. 2002.12.28
12. Гадаадын хөрөнгө оруулалттай АММИ ХХК-ийн газар ашиглалтын гэрээнд өөрчлөлт оруулах тухай Ханбогд сумын засаг даргын захирамж. 2004.07.02
13. Аж ахуйн нэгжид газар ашиглуулах гэрчилгээ. Дугаар 15110012
14. Нисэхийн цаг уурын станц. Ус цаг уур, орчны шинжилгээний газар. Хэмжил зүйн лабораторийн гэрчилгээ. Дугаар 04/001. 2005.10.11 хүртэл
15. Ханбогд сумын засаг даргатай хийсэн Ус ашиглалтын гэрээ-2004-2006
16. Ус ашиглуулах тухай Ханбогд сумын засаг даргын зөвшөөрөл
17. Зам засварын ажил зохион байгуулах тухай ХБ сумын ЗД-ын захирамж
18. Ханбогд сумын засаг даргын хог хаядлын цэг байгуулахыг зөвшөөрсөн бичиг
19. Оюу толгой нисэх буудлын зөвшөөрөл
20. Оюу толгой дахь ШТС-ийн зөвшөөрлийн бичиг баримтууд
21. Шинэ суурингийн инженерийн шугам сүлжээний угсарсан, сорилтоор шалгасан актууд
22. ОТ төслийн байгаль орчны суурь судалгааны тайлан-2002.10
23. ОТ төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт. БОЯ-ны 2003.02.13-ны өдрийн 4/213 тоот бичиг
24. Оюу Толгой - Гашуун Сухайтын зам ба дэд бүтцийн зурвасын БОНБНҮ-ний тайлан. 2003.04.
25. БОХ төлөвлөгөөний биелэлтийн тайлан-2003
26. ОТ төслийн өрөмдлөгийн ажилд ашиглаж буй бодисуудын аюулгүй байдлын мэдээллийн хуудсууд
27. Өрөмдөж дууссан талбайд хийсэн шалгалтын материалууд
28. Зөрчлийг арилгуулах үйл ажиллагааны маягтууд
29. ОТ төслийн хүрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлуудыг сум, орон нутагт үзлэг, шалгалтаар хүлээлгэн өгсөн тухай акт, протоколууд

2007 онд Оюу толгой төслийн хэмжээнд авсан Байгаль орчны холбогдолтой зарим зөвшөөрөл, бичиг баримтуудын жагсаалт

1. Оюу Толгой төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр-2007
2. Хойд хюго ордын газрын гүнд нарийвчилсан хайгуул хийх зориулалт бүхий 1, 2 дугаар босоо ам нэвтрэх үеийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө-2007
3. Оюу Толгой дахь Дугатын хярын ордын дайрганы уурхай, бетон зуурмагийн цехийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр-2007
4. Оюу Толгойн барилгын ажилчдын түр суурингийн бохир ус цэвэрлэх байгууламжийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр-2007
5. Оюу Толгой дахь Ундайн сайрын голдирлын дагуу геотехникийн судалгаа, элсний орд газрын эрэл хайгуулын ажлын байгаль хамгаалах нэмэлт төлөвлөгөө-2007
6. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний төсвийн 50%-ийг төрийн тусгай дансанд байршуулсан төлбөрийн даалгавар
7. Ханбогд сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчийн 2007 оны 02 тоот дүгнэлт, Оюу Толгой орчмын нөхөн сэргээлт хүлээж авсан тухай
8. Ханбогд сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчийн 2007 оны 03 тоот дүгнэлт, Гүний хоолойд хийсэн усны хайгуул, усны кэмп орчмын нөхөн сэргээлт хүлээж авсан тухай
9. Ханбогд сумын Засаг даргын 2007 оны 09 тоот захирамж, элс хайрга авах цэг тогтоох тухай
10. Ханбогд сумын Засаг даргын 2007 оны 20 тоот захирамж, хайрга авах цэг тогтоох тухай
11. Ханбогд сумын Засаг даргын 2003 оны 120 тоот, хог хаягдлын цэг байгуулах зөвшөөрөл олгох тухай
12. Ханбогд сумын Засаг даргын 2006 оны 29 тоот захирамж, хаягдал ус зайлуулах түр цэг байгуулах газар тогтоох тухай
13. Өмнөговь аймгийн Улсын Мэргэжлийн Хяналтын газрын 2007 оны 43/11/07/02 тоот дүгнэлт, хаягдал ус зайлуулах түр цэгийн тухай
14. Ханбогд сумын Засаг даргын 2007 оны 49 тоот захирамж, бохир ус цэвэршүүлэх байгууламжаас гарах хаягдал лагийг зайлуулах цэг тогтоох тухай
15. Өмнөговь аймгийн Мэргэжлийн Хяналтын газрын 2007 оны 43/434/04/202 тоот дүгнэлт, хаягдал лагийг зайлуулах цэгийн тухай
16. Усны хэрэг эрхлэх газрын 2006 оны 4/220 тоот дүгнэлт, оюу толгойд ус ашиглуулах тухай
17. Усны хэрэг эрхлэх газрын 2007 оны 3а/156 тоот, цэвэршүүлсэн усыг дахин ашиглах тухай
18. Улсын мэргэжлийн хяналтын Газрын 2007 оны 05/23/19 тоот дүгнэлт, цэвэршүүлсэн усны шинжилгээний дүнгийн тухай
19. Ханбогд сумын засаг даргын 2007 оны 11 тоот захирамж, Оюу Толгойд ус ашиглах зөвшөөрөл олгох тухай
20. Оюу Толгойд ус ашиглах эрхийн бичиг, дугаар 11102/008
21. Ханбогд сумын засаг даргын 2007 оны 53 тоот захирамж, Усны кэмпэд ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

22. Өмнөговь аймгийн Байгаль орчны албаны 2007 оны 46 тоот дүгнэлт, усны кэмпэд ус ашиглуулах тухай
23. Усны кэмпэд ус ашиглах эрхийн бичиг, дугаар 11102/007
24. АММИ ХХК-ын 2007 оны 2293/9 тоот, ус ашигласан тухай тайлан мэдээ хүргүүлэх тухай
25. Газрын харилцаа, Геодези, Зурагзүйн газрын 2007 оны 1/192 тоот дүгнэлт, АММИ ХХК-ын эзэмшиж буй талбайн газрын төлөв байдал, чанарын хянан баталагааны дүгнэлт
26. Газрын харилцаа, Геодези, Зурагзүйн газрын 2007 оны 1/485 тоот дүгнэлт, 6709А лицензит талбайн газрын төлөв байдал, чанарын хянан баталагааны дүгнэлт
27. Газрын харилцаа, Геодези, Зурагзүйн газрын 2007 оны 1/665 тоот дүгнэлт, Гүний хоолойгоос ус татах байгууламж барих талбайн газрын төлөв байдал, чанарын хянан баталагааны дүгнэлт
28. Усны хэрэг эрхлэх газрын 2007 оны 3а/2113 тоот, Ундайн голын дагууд хийх геотехникийн судалгааны ажлын тухай
29. 2007 онд АММИ ХХК-ын газар эдэлбэрийн, ус, элс ба хайрга авч ашигласны төлбөрийн даалгаварууд

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Оюу толгой ордын техник эдийн засгийн үнэлгээний хураангуй
2. Оюу толгой орд газарт 2005 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан. 2006.1
3. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн тайлангууд -2003, 2004, 2005, 2006
4. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө -2003, 2004, 2005,2006
5. Оюу толгой дахь АММИ компанийн хайгуулын талбайд хийгдсэн байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг шалгаж хүлээж авсан тухай протокол 2006.12.5
6. Нэгдүгээр босоо амны 2006 оны нэвтрэлтийн уулын ажлын төлөвлөгөө
7. Оюу толгой ордод дайрга олборлох ил уурхайн 2006 оны уулын ажлын төлөвлөгөө
8. Ханбогд сумын Засаг даргын элс, сайр авч ашиглах цэг тогтоох тухай захирамжууд 2006. 03.16
9. Оюу толгой-Гашуун сухайтын дэд бүтцийн зурвасын БОНБНУ-ний тайлан /I боть/
10. Галбын говь, Гүний хоолой дахь газрын доорхи усны нөөцийг Оюу толгойд ашиглах төслийн БОНБНУ-ний тайлан /II боть/
11. Оюутолгойгоос зэс, алт олборлох, боловсруулах төслийн БОНБНУ-ний тайлан /III боть/
12. Оюу толгойн Хюго хэсэгт нэвтрэх 1-р босоо амны нэвтрэлтийн БОНБ-ын нэмэлт, тодотгол үнэлгээний тайлан
13. УМХА –аас өгсөн 2006 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 09/35/237 тоот албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тухай тайлан